



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/137

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дахь хэсгийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гацуур модны гэрэл асаах ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах, шинэ жилийн баярын өдөр чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудаар орж, нөхцөл байдалтай танилцах, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон Цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан “Алхам, алхмаар амжилт өөд” сургалтын цайны завсарлага, Баруун бүсийн залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах, ахмад харваач, уяачдад сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэх, сар шинийн баярын үйл ажиллагаа, ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх зардалд нийт 19,860,050 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 19,860,050 (арван есөн сая найман зуун жаран мянга тавь) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 0325
Zah A/137 Ba

Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 12-ны өдрийн
А/137 дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ЗАДАРГАА

Д/д	Арга хэмжээ			Нийт үнэ
1	2			3
1	Гацуур модны гэрэл асаах ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах зардалд	Хүүхдийн бэлэг	50*25,000	1,250,000
2	Шинэ жилийн баярын өдөр чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагуудаар орж, нөхцөл байдалтай танилцах зардалд	Бялуу	10*35,000	350,000
		Витамины багц	10*19,800	198,000
3	“Алхам, алхмаар амжилт өөд” сургалтын цайны завсарлагын зардалд			234,000
4	Баруун бүсийн залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах зардалд			5,657,400
5	Ахмад харваач, уяачдад сар шинийн баяраар хүндэтгэл үзүүлэх	Гарын бэлэг	18*53,900	970,000
6	Сар шинийн баярын үйл ажиллагаа, ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх зардалд			10,124,650
7	Бусад зардал			1,076,000
Нийт дүн				19,860,050

-oOo-